




МОНГОЛЫН
ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



2015 ОН: УЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





ГАРЧИГ

- БИД ХЭН БЭ?**
- ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ**
- ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ**
- ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХЫН ТӨЛӨӨ**
- ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ТАСЛАН ЗОГСОӨ**
- ЭРСДЭЛД БҮЙ ХУВЬ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨ**
- БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ**
- ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД**
- САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
- МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ**
- 2015 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ**

БИД ХЭН БЭ


Эмнэсти Интернэшнл нь хүний эрхийн төлөөх хүмүүсийн дэлхий дахинь хөдөлгөөн юм. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид.

Манай ЭРХЭМ зорилго

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрхийг энэ дэлхийн хүн бүрт эдлүүлэхэд оршино.

Эмнэсти Интернэшнл 150 гаруй улс орон, газар нутагт 7 сая гишүүд дэмжигчидтэй. Монголын Эмнэсти Интернэшнл мэргэжил, сонирхолоороо нэгдсэн 5006 гишүүд, дэмжигчидтэй

Гишүүдийн өсөлт



УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Д.Оюунсүрэн
Удирдах зөвлөлийн
дарга



А.Түвшинтулга
Удирдах Зөвлөлийн
дэд дарга



Ш.Анхмаа
Санхүү хариуцсан
гишүүн



Б.Болорсайхан
Хүний Эрхийн Боловсрол
хариуцсан гишүүн



А.Отгончимэг
Бүлэг гишүүд
хариуцсан гишүүн



Б.Энхтуяа
Кампанит ажил
хариуцсан гишүүн



М.Батбаатар
Кампанит ажил
хариуцсан гишүүн



С.Урангоо
Залуучууд
хариуцсан гишүүн



Я.Мөнхчимэг
Хэвлэл мэдээлэл
хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



Б.Мөнхжавхлан
Хяналтын
зөвлөлийн дарга



С.Очирбат
Хяналтын
зөвлөлийн гишүүн



М.Отгонгэрэл
Хяналтын
зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б.Алтантуяа
Гүйцэтгэх захирал



Г.Амарзаяа
Кампанит ажил
хариуцсан зохицуулагч



П.Мөнхжаргал
Хүний эрхийн боловсрол, кампанит
ажил хариуцсан зохицуулагч



Кэйти Барракко
ЭЗНСЭ-ийн кампанит
ажлын зохицуулагч,
судлаач



Э.Мөнхдэмбэрэл
Сан арвижуулагч



Д.Ариунбулган
Санхүүгийн
ажилтан



Б.Азаяа
Хөгжил, гишүүнчлэл
хариуцсан зохицуулагч



Т.Ариунаа
Санхүүгийн
ажилтан

САЙН ДУРЫН АЖИЛТNUУД

Хүний эрхийн төлөөх үйлсэд сайн дурынхны мэдлэг, ур чадвар, тун чухал тул 2015 онд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад нийт 70 гаруй сайн дурын ажилтан, идэвхтнүүд урт болон болон богино хугацаагаар гэрээ байгуулан 3504 цагийг хүний эрхийн төлөөх үйлсэд хандивлан ажиллаа. МУИС-ийн ОУХСургууль, Отгонтэнгэр их сургуулиас дөрвөн оюутан мэргэжлийн дадлага хийлээ.



Нямжаргал



А.Нинжин



Б.Сумъяа



Б.Уранцэрэн



Г.Ариунболор



Aaron Phillip Kawamura



Лиза



Г.Буд



Г.Отгонням



А.Жанболат



Ж.Болор



Б.Мөнхтuyaа



Э.Төгөлдөр



Т.Дөлгөөн



Г.Гантуул



Т.Лхамсүрэн



Э.Анударь



Г.Болор-Эрдэнэ

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХ



Зорилго, зорилтууд:

- Ядуусын дуу хоолойг сонсгож, эрх чөлөө, нээлттэй ил тод байдал, эвлэлдэн нэгдэх эрх, мэдээ мэдээллээр хангах
- Эрхээ мэдэж, нэхэмжлэх замаар ядуу нөхцөлд амьдарч буй иргэдийг чадавхижуулах
- Төр, төрийн бус оролцогчдыг хариуцлагатай болгох

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн баталгаа: Албадан нүүлгэхээс ангид байх эрх

Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажсан газар өмчлөх эрх нь иргэний үндсэн эрхийн нэг. Гэвч, Монгол улсад уг эрхийн мөн чанарыг ойлгох, хэрэгжүүлэх механизмыг тодорхойгүйгээс олон мянган хүний эрх зөрчигдөх эрсдэлтэй байна.

- Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц, Хил хязгааргүй алхам ТББ-тай хамтран эрдэмтэн багш, судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтэн, албан хаагчдын дунд “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгууллаа. Хурлаар газартай холбоотой үүсч буй бүх эрхийн асуудлыг а) Газрын эрхийн хэрэгжилт, дүн шинжилгээ, б) Газрын эрхийн онол, эрх зүй гэсэн хоёр хүрээнд судлан хэлэлцэв.

Хуралд 120 хүн оролцож, нийт 18 илтгэл хэлэлцэж, санал бодлоо солилцов. Монгол улсын иргэн газар өмчлөх эрхтэйг Үндсэн хуулинд баталгаажуулсан ч хамгаалалтыг бусад хуулинд суулгаж өгөөгүйгээс дагаж гарсан эрх зүйн акт, журмууд нь “due process”-ыг хангаж чадахгүй байгааг хэлэлцэв.

- Гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдан газар өмчлөх, өмчтэй байх эрх нь зөрчигдсөн иргэний гомдол, иргэдийг чадавхижуулах хүсэлтийн дагуу БЗД-ийн 80 гаруй иргэнд сургалт хийснээр тэд өөрсдийгөө хамгаалах, эрхээ шаардах мэдлэгтэй боллоо.
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль болон Газрын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлт нь хүний эрхийг зөрчихгүй байхад анхаарлаа хандуулж, ажиллахыг УИХ-ын дарга, гишүүд, ХЭҮК-т уриалж ажиллав.

Эрхээ мэдэж, нэхэмжлэх замаар ядуу нөхцөлд амьдарч буй иргэдийг чадавхижуулах

- НҮБ-аас батлаж гаргасан МХЗ-ыг 2015 онд дүгнэж, тус байгууллагын Ерөнхий Ассемблейн



70 дахь чуулганы хүрээнд 2016-2030 онд хэрэгжүүлэх Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг дэлхийн улс орнуудын төрийн тэргүүнүүд 2015 оны 9 дүгээр сард батласан билээ. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бүрэн утгаар хэрэгжүүлэх, ажил хэрэг болгохыг төр засгаас шаардах иргэний нийгмийн байгууллагын **#LightTheWay - Замыг гэрэлтүүл** дэлхийн хөдөлгөөн өрнөж, 2015 оны 9 дүгээр сард бид Монголын Эмэгтэйчүүдийн сантай хамтран уг аянд нэгдэж, гишүүд, дэмжигчид мөн 30 гаруй ТББ-ын дуу хоолойг нэгтгэн төр засгаас амлалтаа биелүүлэхийг шаардлаа.

■ Парис хотноо 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр эхлэх НҮБ-ын Цаг уурын өөрчлөлтийн эсрэг бага хурлыг уттан Монголын Эмэгтэйчүүдийн сан, Гүнж төв, Хөөрхөн зүрхнүүд аян, Монголын Эмнести Интернэшнл хамтран Улаанбаатар хотын тулгамдсан асуудлын нэг болох агаарын бохирдлыг бууруулах, дэлхий нийтэд тулгамдаад буй уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох үр дүнтэй арга хэмжээ авахыг уриалан "Масктай марш" алхалт зохион байгууллаа.

■ Хүний эрх ба албадан нүүлгэлт, Замыг гэрэлтүүл, Масктай марш зэрэг үйл ажиллагааны танилцуулга, мэдээллийг иргэдэд тарааж, Монголын Эмнести Интернэшнл-ийн цахим хуудас, Фейсбуук, news.gogo.mn, today.mn, vip76.mn, montsame.mn, new.mn, old.eagle.mn сайт, <https://www.youtube.com/watch?v=WzdeUcCqQiA>



линкээр видео кино, <https://www.youtube.com/watch?v=ly4ursCUGNY> линкээр Тод телевизийн мэдээ мөн "Монгол ньюс" мэдээллийн төвд хэвлэлийн бага хурал хийж олон нийтэд хүргэв.

Төр, төрийн бус оролцогчдыг хариуцлагатай болгох чиглэлээр

■ Бизнесийн салбарт гардаг 5 гол хүний эрхийн зөрчил, бизнес дэх хүний эрхийн зарчмуудын талаарх мэдээллийг" Монголын Энтрепренёруудын Нэгдсэн Чуулган 2015"-ын үеэр 300 гаруй залуу бизнесмэнд хүргэлээ.

■ Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний асуудлаархи баримт бичигт хүний эрхийн хэм хэмжээг хангалттай, тодорхой тусгаагүй талаар анхааруулж, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж ажиллахыг Сангийн сайд, Ерөнхийлөгчийн тамгийн газар болон ХЭҮК-т уриалав.

Амжилт, үр дүн:

 Ядуурал, эдийн засаг нийгэм соёлын эрх, үүн дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, чанартай боловсрол, газрын асуудлаар 6090 хүнд мэдлэг, мэдээлэл түгээж, тэдний дуу хоолойг эрх баригчдад хүргэхэд дэмжлэг үзүүлж, чадавхижуулав.

 300 гаруй бизнесмэнд хүний эрх нь хaa хол тэнгэрийн зүйл биш, бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд байдаг зүйл, хэрвээ буруу арга барил, хандлагаар ажиллавал тэр нь яваандаа хүний эрхийн зөрчилд болдгийг ойлгуулж, хандлагаа өөрчлөх, хариуцлагатай болоход нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ корпорацийн нийгмийн хариуцлагыг олон улсын түвшинд шаардахад хувь нэмрээ оруулав.

 Газартай холбоотой гарч буй хүний эрхийн тулгамдсан асуудлуудад эрх баригчид болоод эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн идэвхитнүүдийн анхаарлыг хандуулав.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ



Зорилго, зорилтууд:

- Гишүүд дэмжигчид, олон нийтэд сургалт, хэллэлцүүлэг хийн чадавхижуулах
- Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн сургуулиудыг дэмжих, хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх
- Малчид, иргэний нийгмийн байгууллагыг чадавхижуулах
- Төрөл бүрийн салбарт түншлэл тогтоох, тэднийг хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд татан оролцуулах

- Иргэдэд хүний эрхийн сургалт явуулж, эрхээ хамгаалах чадвартай болгох

■ Завхан аймгийн иргэний нийгмийн байгууллага, Дөрвөлжин, Ургамал зэрэг 7 сумын 20 гаруй малчинд Хүний эрхийн сургалт явуулж, өөрийн болон бусдын эрхийг хамгаалах тухай мэдлэг, мэдээлэл олгосон. Хүний эрхийн сургагч багшийн сургалт явуулж, дадлага хийлгэн 15 хүнд Хүний эрхийн сургагч багш батламж олголоо.

■ Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургууль, олон нийтийн газар зэрэг 19 газарт сурталчлан “Тэнцэтгэлийг өөрчилцгөө” болон холбогдох гарын авлагыг тараав.

■ Сургагч багш нар цахим орчин дахь хүний эрхийн асуудлаар сургалтын модуль боловсруулж, “Цахим эрин-Хүний эрх-Сэтгүүлч” сургалтыг зохион байгуулав.

■ Хүний эрхийн боловсролын цахим сургалтын талбар үүсгэх, цахим сургалтын модуль боловсруулах ажлыг Монголын Эмнести Интернэшилийн үеийн сургагч



багш нарын хамт хийж а) Цахим хичэээл бэлтгэх агуулга, арга зүй; б) Цахим сургалтын бүрэлдэхүүн хэсэг: цуврал лекц 1, 2 зэрэг сургалтыг 2015 оны 10-12 дугаар сарын хооронд зохион байгуулж, чадавхи бэхжүүллээ.



Хүний эрхэд ээлтэй сургууль

■ 2015 оны 2 дугаар сард Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан "Хүний эрхийн боловсрол-ЕБС-д" уулзалтад оролцон Эмнести Интернэшлийн ХЭЭС хөтөлбөрийг танилцуулахын зэрэгцээ бусад байгууллагын хэрэгжүүлж буй "Аюулгүй сургууль", "Нэг сургууль нэг дэлхий", "Залуучууд хөгжил", "Багш бэлтгэдэг их сургуульд хүний эрхийн боловсрол олгож буй байдал", "Хүний эрхийн боловсрол ЕБС-д болон "Хүүхдэд ээлтэй сургууль" төслүүдийг цаашид хэрхэн уялдуулж, хамтарч ажиллах талаар хэлэлцэв.

■ 2015 оны 5 дугаар сард Хүний эрхэд ээлтэй сургууль /ХЭЭС/ хөтөлбөрт хамрагдсан сургуулиудын ўйл ажиллагаатай танилцах, зөвлөх, дэмжих, санал солилцох уулзалтыг Орхон, Дархан-Уул аймгийн нийт 5 сургууль,

нийслэлийн 2 сургуульд зохион байгуулж, сургуулийн мөрөөдлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар санал бодлоо солилцон идэвхижүүллээ.

■ 2015 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Эмнести Интернэшнлийн үүсгэн байгуулагдсан өдрийг утган Хүний эрхэд ээлтэй сургуулиудын дунд **"Загварлаг илэрхийлэл зарлан сонордуулах хүний эрх"** сэдэвт футболкны өдөрлөг, спортын арга хэмжээг зохион байгууллаа. ХУД-ын 118, БЗД-ийн 102, БГД-ийн 51, Хүрээ тулга, СБД-ийн Өсвөрийн зохион бүтээгчдийн лаборатори ахлах сургууль, Хобби, СХД-ийн 107-р сургуулийн 240 гаруй сурагч өөрсдийн урлан бүтээсэн Хүний эрхийн мессеж бүхий футболка өмсж оролцов.





Түүнчлэн, Орхон аймгийн Эрдэм ахлах, Баян-Өндөр цогцолбор сургуулиуд Эрдэнэт хотод, Дархан-Уул аймгийн Дархан 19, Дархан- Од цогцолбор сургуулиуд Дархан хотод, Багануур дүүргийн Боловсрол цогцолбор сургууль, Эмнэсти-Багануур бүлэг хамтран Багануур дүүрэгт, Эмнэсти-Завхан бүлэг Улиастай хотод, Эмнэсти-Хэнтий бүлэг Өндөрхаан хотод, Эмнэсти-Хөвсгөл бүлэг Мөрөн хотод тус тус энэхүү Футболкны өдөрлөгийг зохион байгуулав.

- ХЭЭС хөтөлбөрт хамрагдсан сургуулийн захидал, хичээлийн эрхлэгч нарын 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн уулзалтаар ХЭЭС хөтөлбөрийн хүрээнд олсон амжилт, өөрчлөлт, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцэв.
- Олон улсын төвөөс 2009-2015 оны хооронд хэрэгжүүлсэн ХЭЭС хөтөлбөрийн үнэлгээг 2015 оны 10-11 дүгээр сарын хооронд хийв.

Тус хөтөлбөрт хамрагдсан Монгол улсын хот, хөдөөгийн 10 сургуулиас 7 сургуулийг сонгож, агуулга, бүлгийн ярилцлагаар судалгаа авсан бөгөөд сургуулийн удирдах болон бусад ажилтан, багш, сурагч, төгсөгчид буюу нийт 2230 хүн үнэлгээнд оролцов. 2015 оны 11 дүгээр сарын сүүлээр Лондон хотноо зохион байгуулагдсан ХЭЭС хөтөлбөрийн 2016-2019 оны Стратеги боловсруулах уулзалтад Орхон аймгийн Эрдэм ахлах сургуулийн багш Л.Ихзаяа, С.Ганчимэг нар оролцож туршлагаа хуваалцав.

- Сургуулийг хүний эрхэд ээлтэй болгох нь сэдвээр SBN телевизийн “Шийдэл” шууд нэвтрүүлэгт оролцон Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн амжилт, сайн туршлага болон “Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь” гарын авлагыг танилцуулж, олон нийтэд хүргэлээ.



Хүний эрхийн боловсролын нөлөөллийн ажил

- МУИС-ийн Философи Шашин судлалын тэнхим, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтран их, дээд сургуулийн дунд уламжлал болгон хүний эрхийн асуудлаарх “**Философи хүний эрхийн уулзварт**” философийн зургаадугаар улсын олимпиадыг 2015 оны 5 дугаар сард зохион байгуулж, ХЭБ-ыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ орууллаа.
- Их, дээд сургуульд хүний эрхийн боловсрол олгож буй сургалтын хөтөлбөрийн талаар хүний эрхийн асуудлаар бодит хэлэлцүүлэг хийлээ.
- “Эрхээ мэдье” хүний эрхийн мэтгэлцээнийг үндэсний хэмжээнд 2015 оны 11 дүгээр сарын 16-наас 12 дугаар сарын 19-ны хооронд зохион байгууллаа. Тэмцээн 2 шаттай явагдаж, хотын 8 дүүрэг, 13 аймгийн нийт 340 гаруй багаас Хан-Уул дүүргийн “Гэгээ” баг улсын аварга багаар шалгарч, Отгонтэнгэр их сургуульд дуртай мэргэжлээрээ нэгдүгээр ангид сургалтын төлбөрөөс 100 хувь чөлөөлүүлэх эрхийн бичгийн эзэд болов. Тэмцээний хоёрдугаар байрт Увс аймгийн “Арга билэг” баг, гуравдугаар байрт Сонгино Хайрхан дүүргийн “Хозиро” баг тус тус шалгарч, өргөмжлэл, зохион байгуулагч байгууллагуудын гарын бэлэг, Отгонтэнгэр их сургуульд дуртай мэргэжлээрээ нэгдүгээр ангид сургалтын төлбөрөөс 50, 25 хувь чөлөөлүүлэх эрхийн бичгээр шагнууллаа. Мэтгэлцээний тэмцээнийг JCI Прогресс салбар байгууллага, Отгонтэнгэр их сургууль хамтран зохион байгуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн боловсролын газар дэмжиж ажиллалаа.



Амжилт, үр дүн:

❖ Хүний эрхийн боловсролыг цахим хэлбэрээр олгох, олон хүнд хүргэх ажлыг эхлэж, гишүүд, хүний эрхийн сургач багш наараа чадавхижуулав.

❖ Эрхээ мэдье мэтгэлцээн жил бүр зохиогддог уламжлалт ажил болсноос гадна улсын хэмжээнд зохиогдож, 340 баг оролцон хүрээгээ тэллээ.

❖ Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь гарын авлагыг хот, хөдөөгийн сургуулиудад тарааж, багш сурагчдыг чадавхижуулахын зэрэгцээ, Монголын улсын оолт амжилт, туршлагыг бусад улс оронд түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулав.

❖ Завхан аймгийн малчид болон иргэний нийгмийн төлөөлөл 40 хүн эрхээ хамгаалж, үйл ажиллагаа өрнүүлэх чадавхитай боллоо.

❖ Хүний эрхийн боловсролыг цахим хэлбэрээр олгох, “Философи хүний эрхийн уулзварт” олимпиад, “Эрхүүлэйгийн айлчлал” зэрэг олон талт хэлбэрээр 50 гаруй байгууллагатай хамтран ажиллав.



ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ



Зорилтууд:

- Монгол улсад цаазаар авах ялыг хуульдаа халахад нөлөөлөх
- Үр дүн нь хүний эрхэд чиглэсэн, харилцан ашигтай харилцааг бусадтай тогтоох
- Улс орондоо явуулж буй ажлыг дэлхий нийтийг хамарсан зорилтуудтай нийцүүлэн явуулах;
- Үйл ажиллагаанд гишүүд дэмжигчдийг өргөнөөр оролцуулах

Нөлөөлөл

- Нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халах тухай 2-р нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ Монгол улс биелүүлж, цаазаар авах ял оногдуулахгүй байх, цаазаар авах ялыг хуулиасаа хасахыг уриалсан захидалыг Хууль зүйн сайд, Гадаад хэргийн сайд болон холбогдох газруудад хүргүүлэв.
- Цаазаар авах ялын эсрэг Азийн бүсийн хуралд Монголоос төлөөлөгчид оролцон үг хэлж, илтгэл тавихын зэрэгцээ Ази тивийг

цаазын ялгүй бус нутаг болохыг уриаллаа. Монголын Эмнэлий Интернэшнл нь ADPAN буюу Ази номхон далайн бүсийн сүлжээний Гүйцэтгэх хорооны гишүүнээр сонгогдон Азийн бус нутагтаяа ялангуяа Зүүн Азийн бус нутагт цаазаар авах ялыг халуулах чиглэлээр нөлөөллийн ажил хийв.


- Хүний эрхийн үндэсний байгууллагуудын уулзалтын үеэр Тайваний Контрол Юань байгууллагын гишүүдтэй Монгол, Тайваний хүний эрхийн нөхцөл байдлын талаар ярилцаж, Тайвань улс цаашид цаазаар авах ялыг халах чиглэл баримтлан, дэвшил гаргахыг уриаллаа.
- Индонез улс мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт цаазаар авах ял ихээр хэрэглэж байгаад санаа зовниж, цаашид цаазаар авах ялыг халахын тулд гүйцэтгэлд моратори тогтоохыг уриалсан захидалд оюутан залуучуудын бүлгийн гишүүд, дэмжигчид нэгдэж, Индонезийн Ерөнхийлөгчөөс цаазаар авах ял гүйцэтгэхгүй байхыг шаардан гарын үсэг цуглуулж илгээв.





Олон нийтийг соён гэгээрүүлэх

- Монгол улсад цаазаар авах ялыг халахад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Нээлттэй нийгэм форумтай хамтран иргэний нийгмийнхэн, олон нийт, судлаач нарт “Үхдэл явж байна” кино хэлэлцүүлэг зохион байгуулав.
- 10-р сарын 10 буюу Цаазаар авах ялын эсрэг дэлхийн өдрөөр Хуульчид, Эмэгтэйчүүд, Эмч нар, Оюутан, Залуучууд, Үйлдвэрчний Эвлэл, Эрэгтэйчүүд, Сэтгүүлч, Багш нарын бүлгийн гишүүд Дэвид Гейлийн амьдрал киногоор их дээд сургуулийн оюутнууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, иргэдэд цаазаар авах ялыг халах дэлхийн чиг хандлагыг таниулах кино хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Хэвлэл, мэдээлэл


- Дэлхий даяарх цаазаар авах ялын хэрэглээний талаарх тоо баримт бүхий “Цаазаар авах ял ба гүйцэтгэл-2014” тайланг хэвлэн гаргаж, холбогдох төрийн албан хаагчид, их дээд сургуулийн оюутан, судлаач, олон нийтэд түгээв.
- Үр дүнтэй бодит хэлэлцүүлэг өрнүүлэх үүднээс цаазаар авах ялын асуудлаар болон Монгол улс цаазаар авах ялыг хуулиасаа халсан талаарх мэдээ мэдээллийг тухай бүрт нь өдөр тутмын сонин, цахим хуудсаар дамжуулан олон нийт хүргэлээ.

Амжилт, үр дүн:

❖ Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12-р сарын 3-ны өдөр “Шинэ эрүүгийн хууль”-ийг соёрхон баталж, цаазаар авах ялыг бүрэн халлаа.

❖ Цаазаар авах ялыг халах дэлхийн чиг хандлагыг 1000 гаруй хүмүүст хүргэж, мэдээ мэдээллийг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 10000 орчим хүмүүст түгээв.

❖ Бус нутагтаа цаазаар авах ялын чиг хандлагыг түгээхэд манлайлав



ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ТАСЛАН ЗОГСОӨ



Зорилго, зорилтууд:

- Монгол улсад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын дагуу үр нөлөө бүхий Үндэсний Урьдчилан Сэргийлэх Механизм (ҮУСМ) байгуулахад нөлөөлөх;
- Эрүүдэн шүүхийн бүх хэлбэр болон бусад зүй бус харьцааг хориглохыг шаардах;
- Улс орондоо явуулж буй ажлыг дэлхий нийтийн зорилтуудтай нийцүүлэн явуулах

Нөлөөлөл

- Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайд нарт "Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журам" нь хүний эрх зөрчиж байгаад анхаарал хандуулан, олон улсын жишиг хэмжээнд нийцүүлэн өөрчлөхийг шаардлаа.
- 8-р сард Эмнести Интернэшнлийн Хонгонгийн бүсийн төвийн Зүүн Азийн орнуудыг хариуцсан судлаач Хирока Шожи Монголд айлчилж, 2015 оны Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар холбогдох төрийн болон иргэний нийгэм, ТББ-ын төлөөлөлтэй уулзаж, ярилцав.
- 8-р сарын 20-28-ны хооронд Монгол улсад зохион байгуулагдсан хүний эрхийн хамгаалагч, эрүүдэн шүүх болон бусад хүний эрхийн асуудлаарх олон улсын хурал, уулзалт, зөвлөлгөөнд оролцож, Монгол улс дахь хүний эрхийн асуудлуудаар санал бодлоо солилцож, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөв.
- НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгээс Монгол улсын хүний эрхийн төлөв байдлын 2-р илтгэлийг хэлэлцэн өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хянах асуудлаар ТББ-уудын Форумд нэгдэж ажиллав.



■ Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, Монгол улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколын дагуу хараат бус Үндэсний Урьдчилан Сэргийлэх Байгууллага байгуулах асуудлаар санал хүргүүлэв.

■ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төслийн асуудлаарх уулзалт ярилцлагад оролцож, шударгаар шүүгдэх эрхийг хангаж байгаа эсэхэд анхаарал тавьж ажиллахыг уриаллаа.

Олон нийтийг соён гэгээрүүлэх

- 2015 оны 6-р сарын 26-ны Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрөөр 55 улс оронд зохиогдсон "ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ХАМТДАА ГҮЙЦГЭЭ" арга хэмжээнд Монгол улс нэгдэж Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хүүхэд хүүхдийн төлөө ТББ, Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар, Батлан хамгаалах Их Сургууль, Хууль сахиулах их сургууль, Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд зэрэг 300 гаруй



дэмжигчид тус бүр 3.5 км замыг туулж, эв санааны нэгдлээ илэрхийллээ.

■ Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрийг тохиолдуулан МҮОНТ, Монгол ТВ, VIP-76 зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран "Эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэг бүхий хараат бус байгууллага байгуулах шаардлагатай юу?" сэдвээр эрдэмтэн судлаач, холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан хэлэлцүүлэг, Монгол улс дахь эрүүдэн шүүх гэмт хэрэг, эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогчид болон эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудлаар ярилцлага хийв.

■ "Нүүдэл Шийдэл" нэвтрүүлгийн үеэр явуулсан санал асуулгад оролцогчдын 81.2% Эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэг бүхий хараат бус байгууллага байгуулах шаардлагатай гэж үзсэн.

■ Нээлттэй нийгэм форумтай хамтран Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрөөр иргэд, иргэний нийгмийнхэнд "Төмөр хошуут сахиусан тэнгэрүүд" киногоор хэлэлцүүлэг зохион байгууллаа.

■ Шударгаар шүүлгэх эрх номын 2 дахь хэвлэлийг орчуулан гаргаж, Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр прокурор, шүүх, цагдаа, мөрдөн байцаах газар зэрэг холбогдох төрийн байгууллагууд, ТББ-үүд, хууль зүйн сургуулиудад хүргүүлж, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

■ Саудын Арабын үзэл санааны хоригдол Райф Бадавиг суллуулах онлайн үйл ажиллагаа өрнүүллээ. Мөн Филиппин, Узбекистан улсад эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн хэрэг дээр оюутан, залуучууд гарын үсэг цуглуулах үйл ажиллагаа өрнүүллээ.



Амжилт, үр дүн, үр нөлөө:

蒙古 улс эрүүдэн шүүх гэмт хэргийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалттай нийцүүлэн тодорхойлсон "Шинэ эрүүгийн хууль"-ийг баталлаа.

Узбекистан, Филиппин улсын эрх баригч нарт хандан эрүүдэн шүүхийг таслан зогсоох, эрүүдэн шүүгдсэн өргөдөл гомдлыг хараат бусаар мөрдөн шалгахыг шаардаж 1200 гарын үсэг бүхий захидалыг илгээлээ.

Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрөөр "Эрүүдэн шүүхийн эсрэг хамтдаа гүйцгээ" дэлхий нийтийн арга хэмжээг дэмжин оюутан залуус, хүний эрхийг хамгаалааг 300 гаруй идэвхтнүүд нийтдээ 1050 км-ээр дэлхийг тойроход хувь нэмрээ орууллаа.

Эрүүдэн шүүлтээс ангид байх, шударгаар шүүлгэх эрхийн гарын авлага, ном товхимолыг түгээх, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар иргэдийг эрхээ хамгаалахад чадавхижуулав.

ЭРСДЭЛД БҮЙ ХУВЬ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨ



Зорилго, зорилтууд:

- Эрсдэлд буй хувь хүн, хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх,
- Хамтран ажиллах байгууллагын хүрээг тэлэх
- Үйл ажиллагаанд гишүүд дэмжигчдийг өргөнөөр оролцуулах

Олон нийтийг соён гэгээрүүлэх

■ 2015 оны 2-р сарын 25-ны өдөр Дэлхийн хүний эрхийн төлөв байдлыг танилцуулах уулзалтаар Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Удирдах зөвлөлийн гишүүн Д.Оюунсүрэн, Хуульчдын бүлгийн ахлагч Р.Очирбал, Сэтгүүлчдийн бүлгийн гишүүн Г.Энхбаатар, Ийгл ТВ-ийн тоймч Г.Ганбаяр нар дэлхийн 160 орны хүний эрхийн төлөв байдал, Бус нутгийн тойм, Монгол улсын хүний эрхийн төлөв байдал, Ийгл ТВ-ийн гадаад мэдээний тойм, Сэтгүүлчдийн хамгаалал сэдвээр танилцуулга хийв. Хэвлэлийн бага хурлын үеэр Эмнести Интернэшнлийн Зүүн Азийн Бусийн Төвийн Бодлогын ахлах зөвлөх Ян Везэлтэй онлайнаар холбогдон Азийн бус нутаг дахь хүний эрхийн асуудлаар дэлгэрэнгүй мэдээллийг сэтгүүлч наарт өглөө. Тус хуралд хэвлэл мэдээллийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл, хууль зүйн их дээд сургуулийн багш, оюутнууд, хувь хүмүүс нийт 50 гаруй хүн оролцож үзэл бодлоо хуваалцаа.

■ Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Онлайн эрх чөлөө” эвслийн Сайд нарын 5-р бага хуралд Эмнести Интернэшнлийн төлөөлөгчид оролцлоо. Цахим орчин дахь мөрдөн хяналтын асуудлаар “4 дэх иргэн” киноогоор байгууллагын гишүүдэд болон иргэний нийгмийн байгууллага, идэвхтэн, хүний эрхийн хамгаалагч наарт хэллэлцүүлэг зохион байгуулав.

Хэвлэл мэдээлэл

■ Дэлхийн болон Монгол улсын хүний эрхийн төлөв байдлын талаарх хэвлэлийн мэдээ, тоо баримтыг www.amnesty.mn сайт, телевиз, өдөр тутмын сонин, вэб сайтууд, FM радио зэрэг 10 гаруй хэвлэл мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд хүргэв.

Яаралтай үйл ажиллагаа

■ Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд, дэмжигчид Тайланд, Малайз, Индонезийн эрх баригч наарт хандан далайд усан онгоцтой хөвж, үхэх аюул нүүрлээд байгаа 8000 орчим дүрвэгч, цагаачдад туслахыг уриалсан, хүлээн авахыг шаардсан онлайн ажиллагаа өрнүүллээ.

■ Тайландын засгийн газарт хандан бичсэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн үүргээ биелүүлж, тайван замаар хуран чуулах





эрхийг хязгаарлаж буй хуулийн зүйл заалтыг халах, үзэл бодлоо илэрхийлсэн оюутнууд, идэвхтнүүдэд тулгаж буй хэргийг хэрэгсэхгүй болгохыг шаардсан захидалыг Монгол улсад суугаа Тайландын вант улсын өргөмжит консулд хүргүүлэв.



Эрхийнхээ төлөө бичицгээ

■ Олон улсын Хүний Эрхийн өдрийг тохиолдуулан 12-р сарын 1-14-ний хооронд Эрхийнхээ төлөө бичицгээ үйл ажиллагааг их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, нийслэлийн зарим дүүрэг, болон Архангай, Дархан, Эрдэнэт, Хөвсгөл, Завхан, Хэнтий аймагт тус тус зохион байгууллаа. Эрхийнхээ төлөө бичицгээ аянаар Иран, Малайз, Мексик, Буркина Фасо, Узбекистан, Мьянмар, Сири улсад эрүүдэн шүүгдсэн, сураггүй алга болсон, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн хэрэг дээр цахимаар болон цахим бусаар гарын үсэг цуглуулж илгээлээ.



Амжилт, үр дүн, үр нэлээ

❀ Эмнэсти Интернэшнлийн тайлан, тоо баримтын талаарх мэдээ мэдээллийг телевиз, өдөр тутмын сонин, вэб сайтууд, FM радио зэрэг 10 гаруй хэвлэл мэдээллийн сувгаар дамжуулан наад зах нь 100 000 орчим хүнд хүргэв.

❀ Эрхийнхээ төлөө бичицгээ үйл ажиллагааны хүрээнд нийтдээ 27000 гаруй гарын үсэг бүхий захидалууд илгээлээ.

❀ Эмнэсти Интернэшнлийн Эрхийнхээ төлөө бичицгээ кампанит ажил АНУ-д 44 жил хоригдсон Алберт Вүдфоксыг суллаж, Буркина Фасогийн Хууль зүй, хүний эрхийн сайд нь охидыг эрт гэрлүүлэхэд хүргэж байгаа хууль, хүчээр гэрлүүлэхийн эсрэг хуулийг шинэчлэх ажлаа эхлүүлэхэд, Мексикт холбооны засгийн газар эрүүдэн шүүсэн гомдлыг мөрдөн шалгах ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч, Мьянмарт үзэл санааны хоригдлуудыг суллуулахад хувь нэмэр оруулж чадлаа. Мөн Узбекистаны эрх баригч нарт дэлхий нийт ажигласаар байгааг сануулж, Иранд Самен Насимыг дүүжлүүрээс соллав.

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ



Зорилтууд:

- Монголын Эмнести Интернэшнл нь бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах,
- Идэвхтнүүдийг шийдэр гаргах түвшинд оролцуулах, манлайллын чадавхийг нэмэгдүүлэх
- Үйл ажиллагааг дэмждэг гишүүд дэмжигчид, идэвхтнүүдийн тоог нэмэгдүүлэх

Удирдлага, манлайлал, байгууллагын чадавх

- Удирдах Зөвлөл нийт 7 удаа хуралдаж, 39 шийдвэр гарган, хэрэгжүүлэлтийг хангав. Хяналтын Зөвлөл З удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажиллав. Шинээр сонгогдсон Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөлийн гишүүд "Манлайлал"-ын сургалтанд хамрагдлаа.
- Монголын Эмнести Интернэшнлийн XVIII Чуулган 6-р сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулдаж, Олон Улсын Зөвлөлийн хурлаар хэлэлцэх шийдвэрүүдэд баримтлах байр суурь, саналыг батлаж, 2016-2019 оны нэн тэргүүнд анхаарч ажиллах стратегийн чиглэлийг тодорхойлж, дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн, Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг сонгон батламжилав.

Бүлэг, гишүүдийг өргөжүүлэх, чадавхжуулах, идэвхжүүлэх чиглэлээр

- Цахим, цахим бус сургалт хэлэлцүүлэг, кампанит ажлын үеэр 1399 шинэ гишүүн, дэмжигчтэй болов. Шинэ гишүүдийн сургалт, кампанит

ажлын чадавхи бэхжүүлэх сургалт, чөлөөт ярилцлага, уулзалт 50 гаруй удаа зохион байгуулдаж, 1400 гаруй гишүүд, дэмжигчид оролцлоо.

- Багш нарын бүлгийн харьяа Баян-Өлгий багш нарын клуб, Хуульчдын бүлгийн харьяа Монголын үндэсний дээд сургуулийн багш, оюутны клуб, Сурагчдын бүлгийн харьяа 23-р сургуулийн сурагчдын клуб тус тус байгуулдаж зохион байгуулалт өргөжлөө.
- Завхан, Хөвсгөл, Архангайн, Хэнтий аймаг дах бүлэг, гишүүд "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх" футбольканы өдөрлөгийг орон нутагтаа тус тус амжилттай зохион байгуулж, орон нутгийн иргэд эв санааны нэгдлээ илэрхийлж оролцлоо.
- Гишүүдийнхээ олон улсын түвшинд манлайлах чадварыг дэмжих зорилгоор Англи хэлний анхан шатны эрчимжүүлсэн 14 хоногийн, дунд шатны яриа, дүрэм орчуулгын 2 сарын сургалтыг тус тус Монгол, Америк багш нартай хамтран зохион байгуулаж 12 манлайлагч гишүүн Сертификат гардан авлаа.





■ Байгууллагын тогтвортой байдал чадавхи, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон улсын, бус нутгийн, үндэсний хэмжээний 30 орчим хурал, семинар, чуулга уулзалт, сургалтанд ажилтнууд болон 60 гаруй гишүүд оролцов.




Үр дүн, үр нөлөө

❖ Эмнэсти Интернэшнлийн 2016-2019 оны нэн тэргүүнд анхаарч ажиллах стратеги батлагдлаа.

❖ Хүний эрхийн төлөөх цахим болон цахим бус үйл ажиллагаанд нийт 13234 идэвхтэн, дэмжигч оролцов.

❖ 2015 онд 796 хүний эрхийн идэвхитэн үйл ажиллагаа өрнүүлж, хүний эрхийн төлөөх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 37189 хүн оролцлоо.



ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД

Эмнэлийн Интернэшнл судалгаа кампанит ажлуудаараа бусдад танигдсан хэдий ч өгөөмөр дэмжигчидгүйгээр энэ бүхнийг хийх боломжгүй юм. Манай орлогын ихэнх хувийг өгөөмөр дэмжигчдийн хандив бүрдүүлдэг.

Хандивласан хөрөнгө нь манай байгууллагын дараах 3 кампанит ажилд хувь нэмэр орууллаа.

- Хүний эрхийн боловсрол
- "Эрүүдэн шүүхийн эсрэг" кампанит ажил
- "Хүнийг хүндэл" кампанит ажил

БАЙГУУЛЛАГА АЖ АХҮЙН НЭГЖ

- Арвай бархан ХХК
- Ариг монгол хаад ХХК
- Байшинт уул ХХК
- Жи Си Ай прогресс
- Итали веган ресторан
- Монгол HD телевиз
- Монголын кадастрын холбоо ТББ
- Монголын мэдээ сонин
- Монголын эцэг эхийн холбоо ТББ
- Монголын Эмэгтэйчүүдийн Сан ТББ
- Нийслэл аудит ББСБ
- Нээлттэй нийгэм форум ТББ
- Отгонтэнгэр Их Сургууль
- Оюу толгой хяналт ТББ
- Улаанбаатар зочид буудал ХХК
- Ургах өнгө ХХК
- Үндэсний номын сан
- ШУА-ийн философи, социологи, эрхийн хүрээлэн
- Хил хязгааргүй алхам ТББ
- Чиглэх ирээдүй ХХК
- Шинэ орчин фильм студи
- ЕБ –ын 118-р сургууль
- Зүүн Хойд Азийн Энх Тайвныг Цогцлоох Нийгэмлэг (NARPI)

ХУВЬ ХҮМҮҮС

- | | | | |
|----------------|------------------|------------------|-----------------|
| ● Б.Алтанцэцэг | ● Т.Дөлгөөн | ● О.Оргил | ● Т.Хулан |
| ● Ү.Амарбат | ● Г.Жамъян | ● П.Отгонтуул | ● Б.Хүчитбаатар |
| ● Э.Ариунзул | ● Б.Золзая | ● А.Отгончимэг | ● Ц.Цэнд-Аюуш |
| ● Т.Баяртготх | ● О.Машбат | ● Э.Отгончууруун | ● Г. Цэцэгээ |
| ● Г.Буд | ● А.Мөнх-Эрдэнэ | ● Р.Очирбал | ● Ж.Цэцэгээ |
| ● З.Буяндаваа | ● Э.Мөнхдэмбэрэл | ● Л.Оюун | ● Э.Энхмаа |
| ● Д.Буянжаргал | ● Б.Мөнхзүл | ● Х.Оюутсэцэн | ● Д.Эрдэнэцогт |
| ● Б.Гансүх | ● Т.Мөнх-Оргил | ● Ц.Саранцэцэг | ● С.Эрдэнэцогт |
| ● С.Ганчимэг | ● Л.Нарангоо | ● Э.Сарангуга | ● А.Эрдэнэчимэг |
| ● Д.Доржсүрэн | ● С.Нажидмаа | ● Х.Содгэрэл | |
| ● Ө.Дөлгөөн | ● С.Нямгэрэл | ● Б.Сумьяа | |

ХҮНИЙ ЭРХЭД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ ҮНЭХЭЭР АМАРХАН



Хүний эрхийн төлөө тэмцэнэ гэдэг нь та заавал гудамжинд уриа лоозон барьж жагсан нь гэсэн үг биш. Эмнэлийн Интернэшнлийн үйл ажиллагааг дэмжих гишүүн болох, мөнгө хандивлах зэрэг нь дэлхий дахинд хүний эрх, шударга ёс авчирахын төлөө таны оруулж буй хувь нэмэр юм.

Та www.amnesty.mn цахим хуудсаар зочлон бидний хийж буй хүний эрхийн төлөөх ажлуудтай танилцан доорх дансаар мөнгө хандивлаж болно.

Голомт банк: 112098352

Хаан банк: 504129271

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



2015 оны санхүүгийн хураангуй тайлан

(USD)

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ			
		2015 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31	2015 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31
		Төсөв	Бодит
Санхүүжилт			
Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт		151,579	152,253
Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт-Азийн холбий хөтөлбөр		8,900	8,469
EARO-ийн санхүүжилт		9,336	11,739
Сан арвижуулах үйл ажиллагааны орлого		75,938	40,828
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДУН		245,751	213,289
Зарцуулалт			
Сан арвижуулах үйл ажиллагааны зардал		16,850	14,995
Хурал, уулзалтын зардал		12,189	10,888
Цалин хөлс		92,078	80,377
Оффисийн зардал		46,213	51,358
Кампанит ажил, төсөл хөтөлбөр ба сургалт		96,361	70,728
Санхүүгийн үйл ажиллагааны зардал		3,191	4,808
НИЙТ ЗАРДЛЫН ДУН		266,682	232,955
Эхний үлдэгдэл			
Балэн мөнгө [касс ба банк]		3,620.21	
Нөөц сан		51,535.52	
авлагы		13,450.03	
өмч		1,656.33	
Эзсийн үлдэгдэл			
Балэн мөнгө [касс ба банк]			10,328.97
Нөөц сан			37,755.26
Урьдчилж талсан төлбөр			48.71
авлагы			2,844.84
өмч			3,494.51



Тайланг боловсруулсан ня-бо:


Т. Ариунна

Ханасан гүйцэтгэх захирал:


Б. Алтантуяа

Аудит хийсэн аудитор:




Ч. Гүнданбаяр /"Сүлд аудит" ХХК/

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ



МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: **Цахиагийн Элбэгдорж**

Засгийн газрын тэргүүн: **Чимэдийн Сайханбилэг**

Арванхоёрдугаар сард цаазаар авах ялыг бүрэн халсан шинэ Эрүүгийн хууль баталсан ба 2016 оны 9-р сараас хэрэгжиж эхлэх юм. Хууль сахиулагчид байцаалтын үеэр хэрэг хүлээлгэхээр эрүүдэн шүүж, зүй бус харьцсан хэрэгт ял завших явдал өргөн тархсан. Хотын оршин суугчид албадан нүүлгэлтэнд өртөх эрсдэлтэй байв. Лесбиян, гей, бисексуал, трансжендер болон интерсекс (ЛГБТИ) хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, халдлага санаа зовоосон асуудал хэвээр байв. Сэтгүүлчид яллагдахаас аиж өөрийгөө цензурдсээр байна. Хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлч нарт хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаагаа явуулахад нь бэрхшээл тулгарсаар байна.

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Хууль сахиулагчид эрүүдэн шүүж, зүй бус харьцсан гэмт хэрэгтээ ял завших нь үргэлжилсээр байв. 2014 онд УЕПДМБА татан буугдсанаар эрүүдэн шүүгдсэн, зүй бус харьцсан тухай өргөдөл гомдлыг хараат бус байгууллага бус цагдаагийн байгууллага өөрөө шалгах болсон нь шударга байдалтай холбоотой санаа зовоох асуудлыг нэмэгдүүлж байна. Зөвхөн тодорхой хэсэг албан тушаалтуудын хэрэг Эрүүгийн хуулийн 251-ээр зүйлчлэгдэн шүүхээр орсон ч мэдүүлэг авахаар хүч хэтрүүлэн хэрэглэсэн бусад хэргүүд хариуцлагаас мултартсан байна. Бие машбодийн эрүү шүүлтийг бодвол сэтгэл санааны эрүү шүүлт нь нотлоход хэцүү байдгаас энэ төрлийн гомдлыг ихэнхдээ хэрэгсэхгүй болгожээ.

ШУДАРГА БУС ШҮҮХ АЖИЛЛАГАА

Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаанаас ангид байх, эрүүл мэндээ хамгаалуулах, гэр бүл, өмгөөлөгчтэйгөө уулзах эрх зэрэг шүүхийн өмнөх шатны эрхийг үгүйсгэх тохиолдууд үргэлжилсээр байв.

Сэжигтэн, түүний гэр булийн гишүүдийг цагдаа, прокурор айлган сүрдүүлсэн, хууран мэхэлсэн тохиолдууд мөн бүртгэгдсэн.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ – АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

Нийслэл Улаанбаатар хотын гэр хороолол (шаардлагатай үндсэн үйлчилгээ дутмаг газар)-ын оршин суугчид орон гэрийг нь хүчээр нүүлгэн шилжүүлж болзошгүй байнгын айдас дунд амьдарч байв. Хот хөгжүүлэх төлөвлөгөө нь ил тод бус, бодлого эсвэл хуулиндаа албадан нүүлгэлтийг хориглоогүй байгаа нь асуудлыг хүндруулж байна. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн зарим оршин суугчид хот хөгжүүлэх төлөвлөгөө ба газар чөлөөлөх гэрээнд хүчээр гарын үсэг зуруулахаар заналхийлж, айлган сүрдүүлсэн тухай гомдол гаргасан.

ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР БОЛОН ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт өргөн тархсан. ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах байгууллагын хэлснээр цагдаагийн ажилтнууд хөндлөнгөөс оролцогдгүй. ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хэрэгт ялгаварлах чиг хандлага хүчтэй байгааг цагдаа илрүүлсэн ч өөрсдөө ЛГБТИ хүмүүсийн эрхийг зөрчигчид болж байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ – СЭТГҮҮЛЧИД

Авилаа, хууль тогтоогчдын үйл ажиллагааг сурвалжлан бичсэнийг нь нэр төрд нь халдсан хэмээж сэтгүүлчдийн эсрэг Монгол улсын Эрүүгийн болон Иргэний хуульд заасан гүтгэлгийн гэмт хэргийг хэрэглэсэн байна. Олон сэтгүүлчид, хараат бус хэвлэлүүд хуулийн санкцаас эмээж өөрсдийгөө цензурдэх болсон.

ЦААЗААР АВАХ ЯЛ

12-р сард УИХ (Парламент) цаазаар авах ялыг бүрэн халсан шинэ Эрүүгийн хуулийг баталсан. Хоёр хүнд цаазаар авах ял оногдуулсан ба нэг нь гэмт хэрэг үйлдэх үедээ 17 настай байсан. Давж заалдах шатны шүүхээс нэгийнх нь ялыг 25 жил хорих ялаар сольсон.

Монгол улс: Цаазаар авах ялын асуудлаарх нээлттэй захидал (ASA 30/2490/2015)

Эмнэсти Интернэшил нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 7 сая гаруй гишүүд, дэмжигчид, хүний эрхийн хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг.

Монголын Эмнэсти Интернэшил
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Их сургуулийн гудамж, #AB центрийн
5 давхар 503 тоот
Утас/Факс: 976-7000-4705
aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

2015 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ

